



“ТАВАН ТОЛГОЙ ТҮЛШ” ХХК ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ТУШААЛ

2018 оны 09 сарын 25 өдөр

Дугаар А/27

Улаанбаатар хот

Журам батлах тухай

“Төрийн болон орон нутгийн өмчийн тухай” хуулийн 20 дугаар зүйлийн 20.10 дах заалт, “Энержи Ресурс” ХХК-тай байгуулсан Улаанбаатар хотын агаарын бохирдлыг бууруулах зориулалтаар шахмал түлш үйлдвэрлэх баяжуулсан эрчим хүчний нүүрс нийлүүлэх гэрээний 4.3.2 болон 9.2 дах заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Түүхий эдийн тээвэрлэлтийн журам”-ыг хавсралтаар баталсугай.
2. Журмын хэрэгжилтийг зохион байгуулж ажиллахыг Тээврийн хэлтэс /Б.Жигжид/-т үүрэг болгосугай.
3. Журмын хэрэгжилтэд хяналт, тавьж ажиллахыг Хууль, эрхзүй, аудитын алба /Л.Батбаяр/-нд даалгасугай

Хавсралт 3 хуудастай.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



М.ГАНБААТАР

“Таван Толгой Түлш” ХХК-ний 2018 оны
09 сарын 25 өдрийн А/24 тушаалын 1 хавсралт



ТҮҮХИЙ ЭДИЙН ТЭЭВЭРЛЭЛТИЙН ЖУРАМ

Нэг. Зорилго

1.1 Энэхүү журмын зорилго нь тус компаниас баталсан замын маршрутаар тээвэрт явж байгаа жолооч, тээврийн хэрэгсэл болон сайжруулсан шахмал түлшний үндсэн түүхий эд болох угаасан мидлинг-ийг /цаашид “ачаа” гэх/ эрсдэлд оруулахгүй аюулгүй тээвэрлэх зөвлөмжийг хангахад оршино.

Энэхүү журам нь “Таван толгой түлш” ХХК-ийн захиалгаар гэрээ байгуулсан ААН-ийн ачаа тээвэрлэх тээврийн хэрэгсэл болон жолоочийн аюулгүй ажиллагааг хангахад чиглэгдэнэ.

Тээвэрлэлт хийх ААН нь Монгол улсад мөрдөгдөж буй MNS 4598-2011 стандартыг дагаж мөрдөж ажиллана.

Хоёр. Хамрах хүрээ

2.1. Ачаа тээвэрлэх тээврийн хэрэгслийн жолооч нь тухайн ангиллын тээврийн хэрэгслийг 3-аас дээш жил тасралтгүй жолоодсон ба мэргэшсэн, эрүүл мэндийн үзлэгт хамрагдсан байна.

2.2. Хөдөлмөрийн тухай хуулийн 5-р бүлгийн 70-р зүйлд зааснаар өдөрт 8 /найман/ цаг ажиллах ба тээвэрт явж байхдаа батлагдсан зогсолтын цэгт хуваарийн дагуу амарна.

2.3. Найман цагаас дээш хугацаагаар тээвэрлэлтийн ажил үйлчилгээг тасралтгүй үргэлжлүүлэх нөхцөлд ээлжийн жолоочийг хамтад нь томилно. Хурдыг Замын хөдөлгөөний дүрмийн 9 дүгээр зүйл 9.3 дах заасны дагуу замын нөхцөл, үзэгдэх орчинд хурдыг тохируулж, 70км/цагаас хэтрэхгүй хурдтай явна.

2.4. Тээвэр хийж яваа жолооч нь хууль тогтоомжид заасан бичиг баримт авч явахаас гадна дараах ачаа тээвэрлэлтийн бичиг баримттай байна. Үүнд:

2.4.1. “Таван толгой түлш” ХХК-аас гаргасан тээвэрлэлтийн маршрут-ын схем, Хөдөлмөр амралтын горимын тэмдэглэл

2.4.2. Тухайн тээврийн хэрэгслийн гэрчилгээ, жолоочийн үнэмлэх,

2.4.3. Тээвэрлэж яваа ачааны падаан /2ш/,

2.4.4. Тээврийн хэрэгслээ ачих, буулгах цэгт хуваарийн дагуу эмх цэгцтэй оруулж, ачилт буулгалтын цэгийн хөдөлмөрийн аюулгүй байдлын зааварчилгааг мөрдлөг болгон ажиллаж, тээврийн хэрэгслийн жин болон түүхий эдийн жинг жинлүүлж ачааны падаантай тулгалт хийн хүлээн авч, хүлээлгэн өгнө. Жолооч нь жингийн хянах самбарын заалтыг жингийн бичигтэй тулгана.

2.5. Зайлшгүй зогсолт хийх тохиолдолд зорчих хэсгийг чөлөөлөн замын баруун гар талыг шахаж, хойно ба урдаа 100 метрийн зайнд ослын зогсолтын тэмдэг тавьж бүрэнхий, харанхуй үед оврын гэрлийг асаах бөгөөд ачааг илгээгч болон хүлээн авагч байгууллагад холбоо мэдээллийн бүх хэрэгсэл ашиглан шуурхай мэдэгдэж, шаардлагатай гэж үзвэл ачааг нүүлгэн шилжүүлэх арга хэмжээ авна.

2.13. Ачаа тээвэрлэж яваа тээврийн хэрэгсэл нь шатахуунаар хүрэлцэхүйц цэнэглэгдэн байна. Зам зуур шатахуунаар цэнэглэх нөхцөлд хот, суурин газрын захад байрласан маршрут-д тусгагдсан Шатахуун түгээх станцаас цэнэглэнэ. Зөөврийн цэнэглэгч машинаар аюулгүй байдлыг хангаж цэнэглэж болно.

2.14. Ачаа тээвэрлэж яваа тээврийн хэрэгсэл нь арын гэрэлтүүлэг буюу эргэх болон тормосны гэрэл бүрэн бүтэн байх бөгөөд харагдахуйц газар ачааны тэвшинд гэрэл цацруулагч суулгасан байна. Гэрэлтүүлэг болон гэрэл цацруулагчийг тээвэр хийж байхад цэвэр байлгана.

2.15. Аянга цахилгаантай нөхцөлд тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг зогсооно. Ингэхдээ тээврийн хэрэгслийг ой мод болон хот суурин газраас 200 метр, машин хооронд 50 метрээс багагүй зайд байрлуулж, тээвэрлэж яваа жолооч ажилтан нь тээврийн хэрэгслээс 200 метрээс багагүй зайнаас хянана.

2.16. Замд тээвэрт явж байхдаа дуут дохио заавал өгөх:

2.16.1. Машинаа асаах үед 1,

2.16.2. Урагшлах хөдөлгөөний үед 2,

2.16.3. Ухрах хөдөлгөөний үед 3 удаа дуут дохио өгнө,

2.16.4. Үзэгдэх орчин хязгаарлагдсан газар,

2.16.5. Дайрах буюу мөргөлдөж болзошгүй аюулын бүх тохиолдолд,

2.17. "Энержи Ресурс" ХХК, Ухаа худгийн уурхай болон Үйлдвэрийн орчинд орсноор үйлдвэрийн дотоод дүрэм, журмыг баримтлан ажиллана.

Гурав.Хариуцлага

3.1. Ачаа тээвэрлэхээс татгалзсаны улмаас болон ААН-ийн буруутай үйл ажиллагааны улмаас учирсан хохирлыг тээвэрлэгч ААН бүрэн нөхөн төлнө.

3.2. Энэхүү журмыг зөрчсөн жолоочийн буруутай үйлдлийн тухай тээвэрлүүлэгч нь тээвэр гүйцэтгэж буй ААН-д мэдэгдэж, холбогдох арга хэмжээг авахуулна.